

**ЦАХИМ ОРЧИН АШИГЛАН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ, ТҮҮНД
ХЯНАЛТ ТАВИХ ЖУРМЫН ТӨСӨЛД ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН
САНАЛЫН НЭГТГЭЛ**

Д/д	Санал ирүүлсэн байгууллагын нэр	№	Журмын заалтууд	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан байдал
1	Цагдаагийн ерөнхий газар 2024.08.22 01/629	Нэг. Зарчмын шинжтэй санал			
		1	2.4 дэх хэсэг	2.4 дэх хэсгийг дор дурдсан агуулгатайгаар өөрчлөн найруулах; "2.4.Хиймэл оюун ухаан ашиглан бүтээсэн сонгуулийн сурталчилгаа, сонгуультай холбоотой мэдээлэл бүхий зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгт "Хиймэл оюун ухаан ашиглан бүтээсэн" гэх таних тэмдэг, эх сурвалж, авсан вэб сайт, аппликейшний тамга зэргийг бичлэг, контентын баруун доод буланд харагдахуйц байршуулсан байдлаар байрлуулах бөгөөд таних тэмдгийг байрлуулаагүй тохиолдолд уг контентыг энэхүү журмын 6.6-д заасны дагуу хязгаарлах арга хэмжээ авна."	Тусгасан.
		2	4.5 дэх хэсгийн 4.5.2 дахь заалт	4.5 дэх хэсгийн 4.5.2 дахь заалтыг дор дурдсан агуулгатайгаар өөрчлөн найруулах; "4.5.2.Шийдвэр гаргасан шалтгаан, нөхцөл байдал, хуулийн үндэслэл, зүйл, заалт, гэмт хэргийн шинжтэй үйлдэл болон хуульд заасан хэрэгжүүлэх технологийн арга хэмжээг тодорхой тусгасан байх."	Тусгасан.
		3	4.7 дэх хэсэг	Төслийн 4.7 дэх хэсгийг дор дурдсан агуулгатайгаар өөрчлөн найруулах; "4.7.Харилцаа холбооны зохицуулах хороо нь авсан арга хэмжээний талаарх мэдээллийг хууль ёсны шийдвэр гаргасан эрх бүхий байгууллагад нэн даруй цахимаар эсхүл цаасаар мэдэгдэнэ."	Тусгасан.
		4	5.1 дэх хэсгийн 5.1.5 дахь заалт	Төслийн 5.1 дэх хэсгийн 5.1.5 дахь заалтын "4 цаг тутамд" гэснийг "2 цаг тутамд" гэж өөрчлөх.	Тусгасан.
2	Иргэний зориг ногоон нам 2024.08.19 03/95	1	4 дэх хэсэг	4 дүгээр зүйл болох Сонгуулийн сурталчилгааны хяналтын горимыг зохицуулсан заалтууд нь шүүхийн бус байгууллагуудын санал, дүгнэлтэд үндэслэн нэр дэвшигчийн цахим хаяг, цахим хуудасны хандалтыг хаах, түр хязгаарлахаар зохицуулсан нь субъектив хучин зүйлийг хамаарч хүний хэвлэн нийтлэх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн зөрчих нөхцөлийг бүрдүүлж болох юм. Түүнчлэн тухайн хүний сонгуулийн цахим сурталчилгаанд саад тотгор учруулах зорилгоор зориуд, санаатайгаар хуурамч санал, гомдол гаргаж, хэлмэгдүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлж болзошгүй.	Тусгаагүй.
		2	6 дэх хэсгийн 6.2.3 дахь заалт	6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтаар цахим хуудас, хаягийг сэтгэгдэл бичихүй тохиргоотой нийтлэхээр зохицуулсан нь нам,	Тусгаагүй.

			нар давшим цахим сурталчилгааг үнэ төлбөргүй явуулж болох боломжийг хааж, төлбөртэй, гуравдагч цахим сурталчилгааны арга, сувгуудыг ашиглахад хүргэж байгаа нь нэг талаар сонгуулийн зардлыг ихээр нэмэгдүүлэхэд хүргэх, нөгөө талаар хөрөнгө мөнгө багатай жижиг нам, эвсэл, нэр дэвшигчдийн хувьд эрх тэгш, ижил нөхцөлөөр цахим сурталчилгаа явуулах боломжгүйд хүргэж байна гэж үзэж байна	
--	--	--	--	--

--oOo--